



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/221

Арвайхээр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 2 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/123 дугаар захирамжийн хавсралтын Н.Бат-Эрдэнэтэй холбогдох хэсэг, 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай” А/122 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0458

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25 ны өдрийн 412/21 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> ) газраас	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> ) газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Н.Бат-Эрдэнэ	ЙК87012810	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	575	М.Дашням	ЙО93090313	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	575	8 дугаар баг, Худалдааны тойруу-1 гудамж, 125 тоот	10 жил.
2	Г.Ганхуяг	ЙЮ76122076	Гэр, орон сууцны хашааны газар	771	Ж.Жаргалсайхан	ЙЮ57041111	Гэр, орон сууцны хашааны газар	771	5 дугаар баг, Өнөр-3 гудамж, 301 тоот	35 жил